

Манмин Мэдээ

№ 49 2014 оны 8-р сарын 3

Израйльд тархсан ариун сайн мэдээ Эзэнийг алдаршуулах болтугай!

Кристал Форумын хөгжмийн фестиваль нь Израйлийн Христэд итгэгчдийг итгэлээр өсөхөд тус дэм болж байна



Израйльд сайн мэдээ анх төрсөн газар хэдий ч Христэд итгэгчид итгэлээ хадгалахад хэцүү Еврейн шашинтай улс юм. Израйлийн Христийн сүмүүд И Жей руг пасторын 2007 оны 7 сарын 23наас эхлэн 777 өдрийн үйлчлэлээр дамжуулан илүү их эрч хүчтэй ажиллаж байгаа билээ. Ялангуяа 2009 онд хийсэн Израйлийн нэгдсэн их цуглааны дараа Израйлийн сүмүүд нэгдэж жил бүр Бурханыг магтан фестиваль хийж алдрыг өргөдөг болсон (Зураг: 2014 онд Кристал Форумын Хөгжмийн Их Наадамд орон нутгийн дуучид Манмины дуучидтай хамт).

Эзэний амьдарч байсан ул мөр одоог хүртэл хадгалагдсан ариун газар Израйльд бас дахин Эзэнийг магтаж буй магтаалууд намуухан орой тэнгэр өөд цуурайтаж байлаа.

2014 оны 5 сарын 24нд орон нутгийн цагаар оройн 6 цагт Кристал Форумын (Израйлийн пасторуудын холбоо) зохион байгуулсан Хөгжмийн их наадам Израйлийн Хайфа дахь ОУ-н Хурлийн Төв танхимд боллоо. Тус үйл ажиллагаанд ойролцоогоор 1000 гаруй хүн Орос, Украин, Филиппин, Финланд, Литф, Хонг-Конг, Өмнөд Солонгос болон Израйлаас оролцож, 180 гаруй оронд шууд цацагдсан билээ.

Магтан дууны удирдагч, Хан Жү гёон (Манмины урлагын зөвлөлийн дэд удирдагч) магтаалын номлогч, "Power worship" бүжгийн хамтлаг болон Израйлийн хэд хэдэн сүмийн магтан дууны багуудтай хамтран гайхамшигтай сайхан урлагын

тоглолтоор Эзэнд алдрыг өргөлөө. Мөн түүнчлэн орон нутгийн пасторууд урлагын тоглолтын дундуур богино хэмжээний сургаал номлож, залбирлыг удирдаж байлаа. Магтан дуу болон үг сургаал нь хоорондоо маш сайн уялдаж ивээл ерөөлөөр дүүрэн байсан.

Манмины магтан дуучид Еврей, Орос, Англи хэлээр маш цэвэрхэн дуулж, гайхалтай сайхан бүжиглэж байсанаас гадна нээлт болон хаалтын тоглолтыг маш чадварлаг хийсэн юм. Оролцогчдын сэтгэл маш их хөдөлж, үзэсгэлэнтэй сайхан хувцас нь яг л Тэнгэрийн орныг санагдуулж байсан гэж байв.

Ялангуяа Магтан дууг удирдсан Хан Жү гёон магтаалын номлогч нь "Тэнгэрлэг Алдар" гэдэг дууг тэнгэрийн орны хэлээр дуулж Эзэнд алдрыг өргөхөд оролцогчдыг сэтгэл баясаж Тэнгэрийн орноос тэнгэр элч бууж ирж байгаа мэт харагдсан гэж байсан. "Power

worship" бүжгийн хамтлаг Израйлийн Уламжлалт бүжгийн цуглааныхантай хамтран бүжиглэж Бурханыг алдаршуулав.

Кристал Форумын ерөнхийлөгч Даниел Розен пастор "И Жей руг пасторын хайр болон залбирлаар бид энэ хэмжээнд хүртэл өсөж, амжилтанд хүрлээ" гэж баярласан сэтгэлээ илэрхийлж байсан юм.

Мөн Кристал Форумын пасторууд хэлэхдээ "Иудейчүүдын дарамт, санхүүгийн хүнд хэцүү асуудлаас болоод урлагын үйлчлэл маш хэцүү байдалд орсон тэр л үед И Жей руг пастор чин сэтгэлээсээ, хайраараа санхүүгээр дэмжсэн юм" гэж ам нэгтэй ярилцаж байсан. И Жей руг пасторын агуу хайрын ачаар бид ариун сайн мэдээг тараагч, эрх мэдэлт хүчийг хүртэл үзүүлэх чадвартай дагалдагч нар болсон юм. Одоо тэд эр зоригтойгоор Эзэний И Жей руг пасторт талархалаа илэрхийлж энэхүү үйл

ажиллагааг зохион байгуулж байна (илүү дэлгэрэнгүйг 4-р хуудаснаас уншина уу).

И Жей руг пастор нь 2007 оноос 2009 хүртэл гурван жилийн турш Израйль даяар Бурханы эрх мэдэлт хүчийг үзүүлж, ариун сургаалуудыг тунхагласан. Ингэж Израйлын Христийн сүмүүдийг хүчирхэгжүүлж, босгон байгуулсан юм.

Үүгээр дамжуулан Израйлын пасторууд Кристал Форумыг үүсгэн байгуулж, 2009 оны 9 сард И Жей руг пасторыг Израйлын Нэгдсэн их цуглааныг удирдахыг урьсан билээ. Энэ цуглаан дэлхийн 220 оронд шууд дамжуулан цацагдаж байсан билээ.

Түүнээс хойш Кристал Форумын урлагын үйлчлэл идэвхитэй хөгжиж Кристал Форумын урлагын их наадмыг жил бүрийн 5-р сард зохион байгуулж Эзэнд алдрыг өргөдөг болсон билээ.

Эв нэгдэлтэй байх мэргэн ухаан

“Харин дээрээс ирэгч мэргэн ухаан нь нэгд ариун, тэгээд амар тайван, эелдэг, ул суурьтай, өршөөл ба сайн үр жимсээр дүүрэн, ялгаварладаггүй, хоёр нүүр гаргадаггүй аж” (Иаков 3:17).



И Жей руг Тэргүүн пастор

Бидний хувьд гэр бүл, ажил, сургууль, бизнесийн салбар гээд байгаа бүх газартаа өөрт ноогдсон ажил үүргээ хамгийн сайн сайхнаар хийхэд, “бүх хүнтэй эвтэй байх мэргэн ухаан” хэрэгтэй. Хэрэв бидэнд ийм мэргэн ухаан байвал олон хүнд урам зориг өгч, тэдний зүрх сэтгэлийг татаж, нөлөөлж бас нэгтгэж чадна. Тэгвэл бид яаж бүх хүнтэй эвтэй байх мэргэн ухааныг олж авч чадах вэ?

1. Эв нэгдэлтэй байхын сүнслэг утга

Эв нэгдэлтэй байхыг хэлний тайлбар толь бичигт “Зүрх сэтгэл баяр хөөртэй, амгалан, өөр хоорондоо эвтэй” гэсэн байдаг. Тэгвэл Бурхан бүх хүнтэй эвтэй байхыг хүсдэг бөгөөд үүний сүнслэг утга нь “Бүх хүнийг хайрлаж чаддаг уужуу тайван, өгөөмөр, нинжин сэтгэл” гэсэн утгатай юм. Энгийн үед хүмүүс өөрт нь таалагддаг, хайртай дуртай хүмүүстэйгээ эв нэгдэлтэй байх нь амархан байдаг бол дургүй хүмүүстэй эвтэй байх гэдэг нь тийм амар биш юм. Гэхдээ бид Бурханд хайртай л бол бүх хүмүүст уужим сэтгэлээр хандан эв нэгдэлтэй байх хэрэгтэй. Харин бидний зүрх сэтгэл сайн сайхан зүйл байхгүй эв нэгдлийг сахиж чадахгүй бөгөөд тийм ч учраас хүнд хэцүү байдалтай нүүр тулвал сэтгэл хямарч тавгүйрхдэг байна.

Тиймд сэтгэлдээ бусадтай эвтэй байхын тулд эхлээд өөрөө өөртэйгээ эвтэй байх ёстой юм. Ингэхийн тулд сэтгэлд буй үзэн ядах, агаархах, ихэрхэх, бардамнах, сэтгэл санаа тавгүйрхэх, дургүйцэх гэх мэт гэм нүглийн бүх төрлийг ухааран ойлгож, хаях шаардлагатай байдаг. Бид өөрсдийнхөө гэм нүгэлтэйгээ тэмцэж, зүрх сэтгэлээ ариусгасаны дараа л өөрөө өөртэйгээ эв нэгдэлтэй байж чаддаг. Ингэж чадвал хань ижил, үр хүүхэд, найз нөхөд, хамт олон, хөршүүдтэйгээ эвтэй байхаас гадна Бурхантай хүртэл эвтэй байж чаддаг байна. Бурхантай эв нэгдэлтэй байна

гэдэг нь Бурхан бид хоёрын дунд ямар ч гэмийн хана байх ёсгүй гэсэн үг юм. Тиймээс хамгийн эхлээд бид бүхэн өөрсдийн гэм нүглийн бүх хэлбэрийг хаяж чадах л юм бол өөрөө өөртэйгээ эв нэгдэлтэй байж чадна. Ингэж өөрөө өөртэйгээ эвтэй байж чадсан ямар ч хүн бусадтай хүртэл эвтэй байж чадна.

Есүс зөвхөн сайн, мэдлэг боловсролтой, даруу төлөв, дуулгавартай хүмүүстэй л эвтэй байгаагүй. Тэр бүх хүнтэй эвтэй байж, мэдлэг боловсрол муутай хүмүүст үйлчилж, тэр ч байтугай татвар хураагчид болон гэм нүгэлтэй хүмүүстэй хүртэл эвтэй байж тэдэнд үйлчилж байсан. Хүн төрлөхтөн Бурхан хоёрыг эвлэрүүлэхийн тулд хорон муу, гэм нүгэл дотор амьдарч байсан бүх хүмүүсийн төлөө Тэр үхсэн юм.

2. Амжилтанд хүргэх түлхүүр нь бүх хүнтэй эвтэй байдлын мэргэн ухаан юм

Бурхан бүх хүнтэй эвтэй байх нь мэргэн ухаан мөн гэж айлдсаны учир нь вэ?

Нэгдүгээрт, Эв нэгдэл гэдэг нь Бурханы хүсэл дотор бүх зүйлийг шийдэх арга зам бөгөөд түүнчлэн Бурханы хүч чадал, ивээл ерөөлийг авах гол суваг юм.

Энэ дэлхий дээр өндөр мэдлэг боловсролтой, нийгэмд дээгүүр байр суурь эзэлсэн ч даруу төлөв байж, олон хүнтэй зөв зохистой харьцаж чаддаг хүмүүс байхад харин зарим нь доод тушаалын хүндээ дээрэлхэж, бардам зан гарган ихэрхэж, дорд үзэн харьцдаг хүмүүс ч бас байдаг. Хэдийгээр тэд гоц авъяас, чадвартай байлаа ч бусдыг дорд үзэж, хүмүүстэй эв нэгдэл хагалаад байвал их зүйлийг бүтээж чадахгүй юм.

Чусон Улсад Жо Кван жо гэдэг нэгэн эр амьдарч байжээ. Тэрээр хаандаа болоод ард түмнийхээ төлөө маш том өөрчлөлтийг хийхийг хүсжээ. Түүний чин хүсэл нь тухайн үеийн улс төрийн хуучны бусармаг муу муухай заншлаас салж, улс орноо баян тансаг, хүчирхэг гүрэн болгох байсан юм. Энэ саналыг нь хаан эхэндээ маш их дэмжиж байсан ч түүний дэндүү их харгис, түрэмгий зан нь бусад сайд түшмэлүүдийг өөрийнх нь эсрэг дайсан болгоод зогсоогүй хилс хэрэгт гүтгэгдэн амь насаа алдахад хүргэжээ. Хэрэв тэр өөрийн авъяас, чадвар, овсгоо самбаа, сэргэлэн зан дээрээ жаахан энэрэнгүй байсан бол мөрөөдлөө биелүүлэх ч байсан байж магадгүй юм.

Энэ мэт хүн өөрийн хийж байгаа ажилдаа олон сайхан гайхалтай зүйлс хийлээ ч бусдад үнэлэгдэж чаддаггүй хүмүүс байдаг. Бусад хүмүүс түүнийг зөвхөн өөрийнхөөрөө л зүтгэдэг, бусдыг

дандаа шархлуулж байдаг гэж ярьдаг. Иймэрхүү хүмүүс бусдын үзэл бодол, нөхцөл байдлыг үл харгалзан зөвхөн өөрийнхөөрөө л бүхнийг хийж, өөрийн доор байгаа хүмүүстэйгээ ч, дарга нартайгаа ч таарч тохирохгүй үргэлж зөрчилдөж байдаг. Тиймээс хүнд хичнээн сайн сайхан мэдлэг чадвар байгаад сайн үр дүнд хүргэх байлаа ч эв нэгдэл хагалж, эвдрэлцэж л байвал энэ нь мэргэн ухаан биш юм.

Хоёрдугаарт, Эв нэгдлийг мэргэн ухаан гэсний учир нь эв нэгдэл хагарвал Бурханы хүч нөлөөг авахад маш хэцүү байдаг учраас юм.

Бурханы ажлыг хийхэд эв нэгдэл маш чухал. Хичнээн ухаантай, өндөр мэдлэгтэй, авъяас чадвартай байлаа ч эв нэгдэл хагалдаг бол Бурханы ажлыг хийхэд тэр хүний хувьд маш хэцүү байдаг. Хийх зүйлсээ төлөвлөж, хийж гүйцэтгэдэг ч хөдөлмөрийн үр жимсийг өгөгч нь Бурхан билээ. Бид Бурханы ажлыг хийж байхдаа эв нэгдлийг хагалвал сатанд өөрсдийнхөө эсрэг яллах боломжийг гаргаж өгч байна гэсэн үг. Энэ тохиолдолд Бурхан бидний төлөө дахин ажиллах боломжгүй болдог.

Хүний үүднээс хичнээн өөрийнхөө хүч чадал, оюун ухаанаа дайчлан, их шургуу ажиллаа ч сайн сүнслэг үр жимсийг гаргаж чадахгүй. Тиймээс зарим хүмүүс чадварлаг бөгөөд Бурханы ажлыг хийх халуун сэтгэлтэй мэт бөгөөд түүнд ямар нэгэн үүргийг даалгаж өгснөөр заримдаа асуудал үүсэх явдал ч бий. Түүнээс болж хүмүүс хэцүү байдалд орж, сэтгэл санааны шарх зэрэг асуудлууд үүсдэг.

Тиймээс Бурханы ажлыг хийхэд эв нэгдэлтэй байна гэдэг нь гайхалтай мэргэн ухаан юм. Хэдийгээр бидэнд хангалттай мэдлэг чадвар байхгүй ч эв нэгдэлтэй байж нэгдэж чадвал Бурхан бидэнд агуу гайхамшигтай чадвар, маш сайн үр дүнд хүрэх баталгааг өгч чадна.

3. Эв нэгдэлтэй байхын тулд зүрх сэтгэлээ сайн сайханаар дүүргэ

Бүх хүнтэй эв нэгдэлтэй байхын тулд зүрх сэтгэлээ сайн сайханаар дүүргэх шаардлагатай байдаг. Эв нэгдэл хагалдаг хүмүүс өөрсдийгөө тийм хорон муу байна гэдгээ мэдэхгүй тохиолдол их байдаг. Тэд гаднаа хичнээн сайн үйлсийн төлөө гэж байгаа ч яг үнэндээ бол өөрийнхөө төлөө, өөрийн эрх ашгийг хайж байдаг учраас л эв нэгдэл хагарч байгаа юм. Харин чин сэтгэлээсээ сайн сайханы төлөө байдаг хүмүүс эв нэгдлийг хагалдаггүй.

Гэрлэсэн хосууд хүртэл өөр өөрсдийнхөө төлөө, өөртөө л нийцүүлэх гэдэг учраас асуудал үүсдэг. Эхнэр нь нөхрөө (эсвэл нөхөр нь эхнэрээ) миний

хүслийг мэдэж намайг ойлгоосой гэж хүсдэг. Хэрэв бид өөрийн эрх ашгийг хайхгүй өөрсдийгөө даруу болгож бусдад үйлчилвэл ямар ч хүнтэй эв нэгдэл хагалахгүй байж чадах болно.

Хэрэв таны зөв юм шиг санагдаж, танд ашигтай, танд илүү таатай тохиромжтой, таныг илүү сайн таниулах зүйлийн төлөө та маргалдаад байгаа бол энэ нь яах аргагүй та өөрийн эрх ашгийг хайж байна гэсэн үг мөн. Хичнээн үнэний сургаалыг сонсч сурлаа ч гэсэн зүрх сэтгэлдээ сайн сайхныг бий болгоогүй бол зохисгүй үг яриа ба үйл хөдөлгөөн гардаг. Та өөрийн эрх ашгийг илүүд үзвэл бусдыг шархлуулж, юу ч хийхээс буцахгүй байдалд хүрч болно.

Сайхан сэтгэлтэй хүн үргэлж бусдыг тайвшруулж амар тайван байлгадаг. Тэд Бурханы хаанчлалын төлөө бусдын эрх ашгийг хайх болно. Бусад хүмүүс шударга бус зүйлийг хийж байсан ч түүнийг үл харгалзан харин бусдын үзэл бодол авъяас чадварыг зөв шударгаар үнэлхийг хичээх болно. Тэдний санаа бодол хэдий зөв байсан ч бусадтай санаа зөрөлдөхгүй шийдэж чадна. Хэрэв бид үнэхээр бусдын төлөө үйлчилж, золиос гаргаж, зөв сэтгэлээр өөрсдийгөө даруу байлгавал ямар ч хорон муу хүнийг өөрчилж, хүлээн авч чадна.

Гэхдээ бид эв нэгдэлтэй байхийг хичээх үед худал хуурмагтай эвлэрэхгүй байх тал дээр маш анхааралтай байх шаардлагатай. Хэрэв бид худал хуурмагтай зөрчилдвөл зүгээр л эвдрэлцэж маргалдахаас зайлсхийх эсвэл бусдаас магтаал сайшаал авахын тулд эвтэй байна гэсэн үг биш юм. Хэрэв нэгэн итгэгч гэр бүлийнхээ хүмүүсийн гуйлт ятгалгаар Эзэний өдрийг сахихгүй байхаар шийдсэн бол энэ нь эв нэгдэл сахиж байгаа хэрэг огт биш харин ч бууж өгч байгаа хэрэг юм. Яг энэ тохиолдолд зөвхөн тэр итгэгчийг сүмд явахыг зогсоохыг оролдож байгаа хүмүүсийн оролдлого ч биш Бурханаас холдож үхлийн замаар явж байгаа хэрэг юм. Зарим хүн гэр бүлийнхэнтэйгээ зөрчилдөхөөс зайлсхийж хуурамч шүтээний өмнө мөргөдөг. Зарим нь даргынхаа шахалтаар хамт олонтойгоо архи уудаг. Энэ нь магадгүй тухайн үедээ эв нэгдэл сахиж байгаа юм шиг санагдавч сүнслэг талаасаа Бурханы өмнө гэмийн хана босгож байна гэсэн үг юм.

Хайрт итгэгч ахан дүүс минь, 1 Петр 3:11д “Тэгээд бузар муугаас эргэж, сайныг үйлд. Амар тайвныг хай, түүнийг мөшгө” гэсэн байдаг. Тиймээс зөвхөн Бурхантай ч биш бүх хүнтэй эв нэгдэлтэй байцгаа. Ингэж Бурханыг ажлыг бүрэн дүүрэн хийх хүчтэй болохыг Их Эзэний нэрээр хүсэн ерөөе!

Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.gcntv.org

Аз жаргалтай итгэлийн амьдралын төлөө өөрийгөө шалгах зүйлүүд

Дэд хууль 10:13-г үзвэл “чиний сайн сайхны төлөө өнөөдөр миний чамд тушааж байгаа ЭЗЭНий зарлиг, тушаалыг дагаж мөрдөхийг шаарддаг бус уу?” гэсэн байдаг. Бурхан хайртай хүүхдүүдээ итгэлийн амьдралаар аз жаргалтай амьдраасай гэж хүсдэг. Тиймээс Таны итгэлийн амьдрал аз жаргалтай байна уу? хэмээн өөрийгөө шалгаж үзэхийг хүсье



□ Би итгэлийн амьдралын хувьд идэвхитэй юу эсвэл идэвхигүй?

Бид идэвхитэй, идэвхигүй итгэлийн амьдралын талаар маш нарийн тодорхой ярьдаг. Хэдийгээр хүмүүс гадна талаасаа харахад яг адилхан юм шиг боловч дотоод сэтгэл, оюун бодлоороо маш өөр ялгаатай байдаг.

Итгэлийн амьдралаар идэвхигүй амьдарна гэдэг нь тэд хэн нэгнээс хамааралтай байхыг хэлнэ. Зөвхөн ахлагч л ямар нэг юм хийхийг хүсвэл хийдэг. Тэд ямар нэг зүйлийг хэн нэгэн хэлвэл, удирдвал эсвэл дэмжвэл хийдэг. Тэд ивээл авч Ариун Сүнсээр дүүрлээ ч буцаагаад дүүрэн байдлаа алддаг. Залбирлын тал дээр нэгэн жишээ авъя л даа. Итгэлийн амьдралаар идэвхигүй амьдарч байгаа нэгэн итгэгч хэн нэгний албадлагаар 10 цаг залбирлаа гэж бодъё. Тэгвэл түүний залбирлын үнэ цэнэ маш бага, ямар ч үнэргүй байх болно. Харин эсрэгээр идэвхитэй амьдарч байгаа итгэгчийн нэг цагийн чин сэтгэлийн залбирал анхилуун тансаг үнэртэй, жинхэнэ өргөл болж чаддаг байна.

Энэ мэт идэвхи, санаачлагатай байж, аливаа

зүйлийг сэтгэл гарган сайн хийх нь амжилтанд хүрч, аз жаргалыг эдэлж, түүнийхээ үнэ цэнийг ухаарахыг хэлнэ. Бурхан хайртай хүүхдүүдэдээ эрүүл саруул, ивээгдсэн аз жаргалтай амьдралаар амьдруулахын тулд тушаал өгсөн. Тиймээс бид Бурханы хайрыг ухаарч ойлгон дуулгавартай байвал Бурханы ивээл ерөөл нигүүлсэлээр дүүрэн итгэлийн амьдралаар аз жаргалтай амьдарч чадна. Бурханыг нэгдүгээрт хайрлаж, баяртай байж чаддаг учраас хүнд хэцүү үедээ ч үзэсгэлэнт Тэнгэрийн орны хүсэл тэмүүлэлээр чин сэтгэлээсээ Бурханд талархаж чаддаг хүмүүс бий.

Тэгвэл яагаад зарим хүн идэвхигүй итгэлийн амьдралаар амьдардаг вэ? Итгэлийн жинхэнэ утга учрыг ойлгоогүй учраас тэр юм. Итгэлийн амьдралын тодорхой зорилго ба утга учир, шалтгааныг нь ойлгосон үед л итгэлийн амьдралаар идэвхитэй, гал халуун амьдарч чадна. Тэгээд Бурханы үг сургаалыг сонсож, залбирах дуртай болно. Сүмд хэний ч албадлагагүйгээр явахыг хүсч, бусад итгэлийн

ахан дүүстэйгээ хайраа хуваалцаж нөхөрлөдөг. 1 Петр 2:5д “Иймд амьд чулуу мэт болсон та нар ч Есүс Христээр дамжуулан Бурханд тааламжит, сүнслэг тахилуудыг өргөх ариун тахилч болохын тулд сүнслэг байшин болон баригдагтун” гэж бичигдсэнээр Бурханы хүүхдүүд Есүс Христээр дамжуулан Бурханд тааламжит, сүнслэг тахилуудыг өргөх ариун тахилч нар болох хэрэгтэй гэсэн байна.

Мэдээж, бид итгэлийн амьдралаар зөвхөн өөрийн хүч чадлаар амьдарч чадахгүй. Тиймээс хайрын Бурхан маань бидэнд туслагч Ариун Сүнсийг илгээсэн. Хэн ч гэм нүглээ хүлээн зөвшөөрч гэмшиж, Есүс Христийг хүлээн зөвшөөрвөл Ариун Сүнс бидний зүрх сэтгэлд ирж бүх зүйлийг зааж, сануулж, үнэн рүү биднийг удирдана (Иохан 14:26, 16:13). Бидний итгэл өсөх хүртлээ хэсэг хугацаанд идэвхигүй амьдарч, бусдаас зөвлөгөө, тусламж авах хэрэгтэй болдог. Гэхдээ итгэлээр өссөнийхөө дараа Ариун Сүнсэнд итгэлээрээ залбирч, Бурханаас хариулт авахыг хичээн зүтгэх нь их чухал юм.

□ Миний зорилго чухал уу, эсвэл зорилгодоо хүрэх үйл явц чухал уу?

Тодорхой зорилго тавих нь мөрөөдлөө биелүүлж амжилтанд хүрэхэд маш чухал. Гэхдээ олон чухал зүйлсийг зорилго болгон тавьчихаад явцын дунд хэрэгжүүлэхгүй орхичихвол энэ нь тийм ч сайн хэрэг биш.

Сүнслэг зүрх сэтгэлийг бий болгон гэдэг нь Бурханы зүрх сэтгэлийг илүү гүнзгий мэдэрч, баяр хөөртэй, амар амгаланг олон үйлявц юм. Үүнийг хүсэн тэмүүлж буй хүн нь өөрийгөө цэвэрлэж, худал хуурмаг муу муухай зүйлээ хаях үед баяр баясал, аз жаргалыг мэдрэх болдог. Гэвч зорьсон зүйлийн эцсийн үр дүнг чухалд тооцдог хүнд худал хуурмагийг хаяж, өөрийгөө цэвэрлэх үйл явц хэцүү төвөгтэй мэт санагддаг.

Хэрэв та жинхэнэ итгэлийн амьдралаар амьдарвал зорилгодоо хараахан хүрээгүй ч уйтгар гуниг, өвчин зовлонг мэдрэхгүй харин аз жаргал, баяр хөөр, итгэл найдвараар дүүрэн амжилтыг олж чадна. Зорьсон зорилгодоо хүрэхийн тулд бид бүхэн алхам бүрдээ

өөрсдийн зүрх сэтгэлээ шалгаж байх хэрэгтэй. Хэдий жижигхэн ч гэсэн амьдралдаа тулгарсан бүх зүйлд сайныг л үйлдэж, алхам тутамдаа бага багаар итгэлийн алхамаар алхах хэрэгтэй.

Таны хайр агуулсан ганц үг, нойроо хугаслан байж хийсэн залбирал, завгүй байхдаа ч уншиж байсан библи, эдгээр нь сүнсний хувьд хураагдсаар илүү хурдан зорьсон зүйлдээ хүрч чадна. Итгэлийн амьдрал бол хамгийн ариун итгэл дээр өөрийгөө босгон байгуулахтай л адилхан юм (Иуда 1:20).

Хэрэв таны хамгийн гол зорилго тань Тэнгэрийн орны хамгийн үзэсгэлэнтэй газар болох Шинэ Иерусалим, Бурханд таалагдсан итгэл болох төгс сүнс гэсэн зүйл таны зорилго бол итгэлийн амьдралаар аз жаргалтай амьдарч чадна (Илчлэлт 21:2; 1 Тесалоник 5:23). Зорилго нь өөрөө тийм ч чухал зүйл биш харин зорилгодоо хүрэхийн тулд хийх алхмууд нь ямар их чухал болохыг та мэдэрч, бүр нандигнах болно.

Матай 20: 20-н сүүл хэсэгт харвал Иаков, Иохан хоёрын эх нь Есүс дээр ирж хоёр хүүгээ нэгийг нь баруун талдаа нөгөөг нь зүүн талдаа суулгахыг гуйхад Есүс “Миний уух аяганаас та нар ууж чадах уу?” гэж асуудаг. Яг тэр үед Түүний дагалдагч нар ‘аяганаас уух’ гэдэг нь ямар агуу ивээл, ерөөлийн зам болохыг ойлгож ухаараагүй байсан. Харин Ариун Сүнсийг хүлээн авсаныхаа дараа тэд утгыг нь ойлгож ихэнх нь Эзэний агуу хайр шингэсэн ‘аяга’-наас уусанаараа Түүний хаанчлалд хамт байх болсон (Лук 22:28-30).

Тиймээс, Бурханы алдраар дүүрэн Шинэ Иерусалимд орохын тулд өгөгдсөн нөхцөл байдал дотроо Бурханы шударга ёсны дагуу бүх зүйлийг нэг нэгээр нь хураан хуримтлуулах хэрэгтэй. Баттай итгэх итгэл, хүсэл тэмүүлэл дотор зорилго руугаа хандан баяр хөөр, аз жаргалтайгаар давших үед л төгс сүнсний зүрх сэтгэлийг бий болгож, Шинэ Иерусалимд гэсэн туйлын зорилго маань биелэх болно.

“Одоо Израйлийн үйлчлэл амархан болсон”

Сергей Вочарников пастор
(Назарын Амьд Сүнс Сүм, Израйль)



Би Украйнд төрсөн еврей хүн. Манай гэр бүлийнхэн Орост нүүж ирээд эхнэртэйгээ танилцан, Эзэнийг хүлээн авсан. Эхнэрийн маань гэр бүл еврейн итгэгч, хадам аав маань пастор хүн байсан. 1989 онд эхнэр бид хоёр, түүний гэр бүлийнхэн Израйлийн Хайфад нүүж ирээд үйлчлэлийн ажлаа эхэлсэн.

1990 оны эхээр Зөвлөлт холбоот улс нээлттэй болж олон Орос улсад байсан олон Еврей хүмүүс Израйл руу нүүж, сайн мэдээ тараахыг хичээж байлаа. 1994 онд би пастор болж Есүсийн өссөн Назар хотод үйлчлэлээ эхэлсэн. Гэхдээ еврейн шашинтай Израйль ард түмэнд сайн мэдээ тараах тийм амар хялбар байгаагүй юм.

Израйлын пасторуудыг нэгтгэж чадсан Кристал Форумын үр дүн

2004 оны нэгэн өдөр Германы Александр Еэп пастор над руу утасдаж И Жей руг пасторын Германд хийх нэгдсэн их цуглаанд оролцохыг ятгасан юм Тэрээр тухайн үед Германд хийх нэгдсэн их цуглаанд зохион байгуулах хорооны даргаар ажиллаж байсан яг тэр үед оролцох боломжгүй байсан тул дэд пастораа явуулсан юм. Түүний дараахан И Жей руг пасторын амь бялхсан гайхалтай сургаал ба гайхамшигт эрх мэдэлт хүчний үйлсүүдийг хүлээн авсан юм.

Ариун Сүнсний эрх мэдэлт хүчийг агуулсан агуу зүйлийн талаар сонсоод сэтгэл минь хөдөлж байсан. Хэдийгээр би сүм тариад 10 жил болсон ч санхүүгийн болоод еврейчүүдийн дарамтанд хэцүү л байдаг байсан. Харин И Жей руг пасторын энэ үйлчлэл надад Израйльд сайн мэдээ тарааж, номлох цоо шинэ алсын хараа өгсөн.

Ингээд 2005 оны 10 сард Манмин Төв Сүмийн 23 жилийн ойн баярт би өөрийн зардлаараа очиж оролцсон. Урлагын тоглолтууд нь надад Тэнгэрийн орныг санагдуулж байсан ба Мөн И Жей руг пасторын гайхамшигт сургаалууд түүнчлэн орой бүрийн Даниел залбирал нь сүмийн сэргэлтэнд маш их чухал болохыг би ухаарсан.

Удаан хугацааны дараа Сүнсэлэг удирдагчтай уулзаж Израйльд сайн мэдээг тараан номлохыг хүсэж олон жилийн залбирч байсныхаа хариултыг авч чадсан тул өөрийнхөө сүмийг Манмин Төв Сүмийн салбар сүмээр бүртгүүлсэн билээ. Үүний дараа 2006 оны Нью Йорк, Конгогийн нэгдсэн их цуглаанд оролцож асар олон хүн эдгэрч, хариулт авч, Бурханыг алдаршуулж байгааг өөрийн нүдээр харсан билээ.

2007 оны 7 сараас эхлэн И Жей руг пастор Назараас эхлэн гурван жилийн турш 12 удаа эрх мэдэлт хүчийг харуулж, ариун зар, сургаалуудаа номлосон билээ. 2007 оны 7 сарын 25 нд тэр үйлчлэлээ манай сүмээс эхлэн анхныхаа цуглааныг хийсэн нь миний сэтгэлийг асар их хөдөлгөсөн.

Түүний 3 жилийн үйлчлэл израйлын еврейчүүдэд урам зориг өгч, үүний үр жимсээр Кристал Форум

(Израйлийн пасторуудын холбоо) нэгдэж чадсан юм.

Израйлийн Нэгдсэн Их Цуглаанд И Жей руг пастор Есүс Христийг тунхагласан

2009 оны 9 сард И Жей руг пастор Израйлийн төвд, Олон улсын соёлын төвд нь Израйлийн Нэгдсэн их цуглааныг удирдан явуулсан билээ. Тус цуглаан 220 гаруй оронд 33 нэвтрүүлгийн сувгаар цацагдсан. И Жей руг пастор Бүтээгч Бурхан, Есүс Христын тухай зоригтойгоор тунхаглаж байв. Яг үнэнийг хэлэхэд маш олон пасторууд Израйльд ирж номлож байсан ч зөвхөн Есүс л бидний Аврагч мөн гэсэн сүнсэлэг утгыг ийм товч тодорхой хэлж, зааж байгаагүй юм. Харин И Жей руг пастор еврейчүүдэд номлож, Библид бичигдсэн гайхамшигуудыг бодитоор харуулж байсан билээ.

Израйль бол анх сайн мэдээ төрсөн газар хэдий ч ард түмэн нь Есүс Христийг Аврагчаар хүлээн зөвшөөрдөггүй байсан. Хэдхэн итгэгч хүн байдаг ч тэднийг нийгмээс гадуурхан хавчдаг байсан ч тус нэгдсэн их цуглааны дараа Христэд итгэгч еврей хүмүүс эрч хүч, эр зоригтой болж Эзэнийг магтан дуулж задгай театрт хүртэл Кристал Форумын урлагын их наадам хийдэг болсон.

Олон пасторууд И Жей руг пасторын энэ үйлчлэлээс эдгэрэл, ариуслын ивээлийг авсан. Ариухан амьдрал гэж юу болохыг ухаарч ойлгосноос хойш бүх гэм нүглээ хаяж, бүр оюун бодол, сэтгэл зүрхэндээ ч хүртэл гэмгүй байхыг хичээж, сүмийн итгэгчиддээ үргэлж зааж, номлодог болсон.

Израйль нь Есүс Хрисийн мэндэлсэн ариун газар учраас гадаадаас олон пасторууд ирдэг. Тэд биднийг хараад Еврейн шашинтай энэ улсад сайн мэдээг

номлоно гэдэг хэцүүг хараад бидэнд туслана гэж хэлээд явдаг ч нэг нь ч амласандаа хүрч чадаагүй байсан юм.

Харин И Жей руг пастор Бурханы авралын гол зорилгыг бидэнд зааж, “Дэлхийн хязгаар хүртэл” сайн мэдээ тараахаар эргэн ирж бидэнд санхүү болоод сүнсэлэг тусламжийг харамгүй өгч тасралтгүйгээр биднийг дэмжиж байсан юм. Тиймээс Израйлын пасторууд эр зоригтойгоор ариун зар сайн мэдээг тунхаглаж, И Жей руг пасторын залбирч өгсөн гар алчуурын (Үйлс 19:11-12) цуглааныг олон газар хийсээр байгаа.

Би ч бас Энэтхэгт гар алчуурын цуглааныг жил бүр хийж, эрх мэдэлт хүчээр архаг архицид архинаас гарч, эдгэшгүй өвчтэй олон хүн эдгэрэхийг өөрийн нүдээр харсан. Бүх алдар магтаал, хүндэтгэлийг авралын эцсийн үеийн зорилгоо И Жей руг пастораар дамжуулан ажлаа хийж байгаа Бурханд өргөж байна.



И Жей руг пастор нь 2009 оны Израйлийн Нэгдсэн Их Цуглааныг Израйлын төв хэсэгт зохион байгуулж, гайхалтай амьд сургаал номлон, эрх мэдэлт хүчийг харуулж залбирлаараа асар олон хүнийг эдгээж бүх алдрыг Бурханд өргөсөн билээ. Тус цуглаан 220 гаруй оронд TV, радио, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр цацагдаж, үй олон хүн аврал, эдгэрэл, ивээл ерөөлийг хүлээн авсан юм.



УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойши мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч: Г. Анхбаяр СМТ 976-91173712 976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

Сөүл хот, Гүрү дүүрэг, дижитал-26-29 тоот 152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminministry@manmin.org
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин